



ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/67

Жаргалант

Бог малын хээлтүүлэгчид
үзлэг ангилалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 16 дугаар зүйлийн 16.8.6, 16.9.2, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хэмжээнд бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад бүрэн хамруулж ашиг шимийг тогтоож бүртгэлжүүлэх ажлыг 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 14 хоногт багтаан шуурхай зохион байгуулсугай.

2.Бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад хамруулж ашиг шимийг тогтоож бүртгэлжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Э.Батдаваа	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн менежмент, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүдэд	Х.Амарбаясгалан А.Уранчимэг Э.Бат-Орших Г.Оюунчимэг Ж.Лхагвапүрэв	Баян-Өлзийт багийн Засаг дарга Ангирт багийн Засаг дарга Онон багийн Засаг дарга Жаргалант багийн Засаг дарга “Зүүн лодой” ХХК захирал

3.Сумын хэмжээнд бог малын 1205 хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржлийн бүртгэл, бэлчээр, усжуулалт хариуцсан мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч (Э.Батдаваа)-д үүрэг болгосугай.

4.Үзлэг ангилалтад зарцуулах 5,000,000 (таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Баасансүрэн), бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад бүрэн хамруулж дүнг 06 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржлийн бүртгэл, бэлчээр, усжуулалт хариуцсан мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч (Э.Батдаваа)-д нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501055

Министерство культуры
и наследия
России
О. Н. Мухоморов

[Handwritten signature]

